

АЛТАЙ УРИАНХАЙН ДОЛООН ХОШУУНЫ ГАЗРЫН ЗУРГИЙН ТУХАЙ

КАМИМУРА Акира

ОРШИЛ -Газрын зураг юу өгүүлж, юу дамжуулж чадах вэ?

Газрын зураг зөвхөн газрын гадарх байдлыг товчоолон үзүүлдэг биш юм. 1987 онд хэвлэсэн “Газрын зураг зүйн түүх” хэмээх номын оршилд Harley ба Woodward газрын зургийг “graphic representations that facilitate a spatial understanding of things, concepts, conditions, processes, or events in the human world” гэж тодорхойлсон байдаг. “Ертөнцөд байгаа юм, төсөөлөл, байдал, үйл явц, үйл явдлыг орон зайн хувьд авч ойлгоход дөхөм болгох” гэсэн энэхүү зориулалтаас гадна, тухайн хүмүүс газартаа яаж хандаж ирсэн, тэдний хувьд тэр газар юу болохыг илэрхийлж бусдад дамжуулдаг үүрэг ч газрын зурагт байгаа.

Одоо Монголд байгаа хуучин хошуу, аймгуудын газрын зураг тухайн үед харьяалагдаж байсан засгийн газарт өргөн барьсан эх юм уу, хуулбар юм. Нутгийнхаа газрын зургийг өргөн барих гэдэг нь тэр засгийн газарт үнэнч шударга байхыг илэрхийлэх явдал болно. Газрын зургаар дамжуулж санаагаа нөгөө талын хүмүүст мэдэгдэж болдог, өөрөөр хэлбэл, газрын зураг ямар нэг зүйлийг илэрхийлж дамжуулан, мэдээлэх хэрэгсэл (media) мөн гэсэн үг.

Тус өгүүлэлд авч үзэх Алтай урианхайн дөрвөн газрын зураг ийнхүү газрын зургийн үүргийг харуулах жишээ болно. Алтай урианхайчууд газрын заргаар нутгийнхаа тухай гомдол, шүүмжлэлээ ч гэсэн Чин улс, Монгол улсын засгийн газарт мэдүүлдэг байсан гэж хэлж болно. Энэхүү өгүүлэлдээ Алтай урианхайчууд газрын зургаар чухам ямархуу санаа илэрхийлж дамжуулах гэж байсан бэ? гэдэг асуудалд хандаж, газрын зургийн “илэрхийлэх, дамжуулах” үүргийг нь илүүтэй тодруулах гэсэн юм.

1. Алтай урианхайн долоон хошууны зураг

Энэ дөрвөн газрын зураг одоо Алтай урианхайчууд оршин суудаг Алтайн нурууны ар, өвөр талаас бүр баруун тийшээ, Зайсан нуур болон Эрчис, Бөгтөрмаа хоёр мөрний наадах газрыг хамруулсан өргөн уудам нутгийг үзүүлсэн зураг болно. Уул, гол мөрний байршил нь бараг адил, үндсэндээ нэг загвартай бөгөөд Алтайн Шар сүм (Соёлыг эрхэлсэн сүм)-ийг зургийн дунд нь байрлуулсан нь буддын шашин ард түмний амьдралд томоохон байр эзэлсэн тухайн үеийн нийгэм соёлын шинж, ертөнцийг үзэх үзлийн илэрхийлэл гэж хэлж болно. Дөрвөн зураг нэг загвартай боловч, тус тусдаа өөр засгийн газарт өргөн барьсан юм.





Акира Камимура

Токиогийн Гадаад судлалын их сургууль
kamimura.akira@tufs.ac.jp


С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимура

Монголын газрын зураг, газрын нэр судлал
“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

Хүснэгт 1 Алтай уринахайн долоон хошууны нутгийн зургийн жагсаалт

	Газрын зураг	Он сар өдөр	Тамгийн бичиг	Он	Хадгалагдаж буй газар
1	 <p>(Алтай Урианхайн баруун, зүүн гарын нутгийн зураг)</p>	badarayultu törö-yin arban jiryuduyar on jiryuyan sarayin arban yurban_a	1. altai-yin uriyangqai-yi jakiryuči jegün yar-un bügüde-yin daruy-a- yin tamay-a, 2. altai-yin uriyangqai-yi jakiryuči barayun yar- un bügüde-yin daruy- a-yin tamay-a	1890	Монгол улсын Үндэсний номын сан
2	 <p>(Dörböd-ün barayun ayimay-un sula sayid güng baldangdorj güng yalsangjab narun doloγan qosiyun-u uriyangqai-yin qariyatu nutuy-un jiryu nigen qamtu)</p>	olan-a ergügdegsen-ü yurbaduyar on arban sarayin qorin tabun	altai-yin uriyangqai- yi jakiryuči barayun yar-un bügüde-yin daruy-a-yin tamay-a	1913	<i>Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн Альбом.</i> (ТХЗА) Улсын геодези, зураг зүйн газар. УБ. 1986; МУНС
3	 <p>烏梁海左右翼七旗地圖 (Урианхайн зүүн, баруун гарын долоон хошууны нутгийн зураг)</p>	dumdatu irgen ulus-un naimaduyar on arban qoyar sarayin	altai-yin uriyangqai- yi jakiryuči barayun yar-un bügüde-yin daruy-a-yin tamay-a	1920	Берлин мужийн номын сан, Hs.or.123
4	 <p>[Altai-yin uriyangqai-yin doloγan qosiyun-u nutuy-un jiryu]</p>	mongyol ulus- un arban naimaduyar on tabun sarayin qoyar	altai uriyangqai-yin jidgültü jasad-un qosiyu-yi jakiryuči tamay-a	1928	Library of Tokyo University of Foreign Studies (http://mongol.tufs.ac.jp/landmaps/17S.html)

1.1 Алтай Урианхайн баруун, зүүн гарын нутгийн зураг, Бадаргуулт төрийн арван зургадугаар он зургаан сарын арван гурван (1890)




Зураг 1 Алтай урианхайн баруун, зүүн гарын нутгийн зураг (1890) Улсын Үндэсний номын сан

1-р зураг нь дөрвөн газрын зургийн дотор хамгийн эрт буюу Бадаргуулт төрийн 16 онд үйлдсэн зураг болно. Үүнийг “Зарлигаар тогтоосон Дайчин улсын хураангуй хууль бичгийн газрын зураг” (欽定大清會典輿圖)-т зориулан Бадаргуулт төрийн 15-р (1889) оны “нэг жилийн дотор муж (省), сум (府), хорооны (縣) зургийг хийж, зурган тайлбартайгаар Хууль бичгийн хүрээн (會典館)-д ирүүлэх”-ийг тушаасан мэдэгдлийн дагуу (Камимүра 2012:8) үйлдсэн юм.


Бадаргуулт төрийн 16-р (1890) оны 6 сарын 13-нд тус зургийг үйлдсэний дараа Ховдын бусад аймгуудын зурагтай нийлүүлж “Ховдын хязгаарын газрын зураг” (Зураг 2)-ийг Бадаргуулт төрийн 16-р оны 6 сарын 28-нд үйлдсэн юм. Үүний тухай Зураг-2 дээр “Бадаргуулт төрийн 16-р онд зарлигаар газар орны зураг хэмжээг шинэ нарийн зураг зурж, өргөн хүргээр ирүүлж, хууль бичигт зохион оруулъя хэмээн тушаасанд, бид Ховдын харьяат олон хошууны ноёд түшмэд цөм Ховдын газраа хурж, тус тус харьяат нутгийн харилцан нутгийн зураг, жич харьяат яамны зургийг цөм харилцан нийлүүлж, нэгэн хуудас болгон шинэ нарийн зураг зурж, Хууль бичгийн хүрээнээ өргөсөн зургийн эхийг тус тус нэгэн хувь хадгалсан болой” (ГХЗА

1986: 15) гэж тайлбарласан байдаг. Халхын дөрвөн аймгийн хувьд Бүрэнт засагчийн гуравдугаар (1864) онд Олон улсын хэргийг ерөнхийлөн шийтгэх яамнаас “бие тулж” хэмжсэн шинэ зургийг үйлдэхийг тушаасан тушаалын ёсоор шинэ нарийн зургийг үйлдсэн билээ (Камимүра 2012:5). Энэ тушаал Ховдын хязгаарыг хамраагүй байсан бололтой.


“Зураг 1”-ийг Ховдын хязгаарын газрын зурагтай (Зураг 2) “харилцан нийлүүлэх”-эд зарим нэг өөрчлөлт оруулсан байжээ. Нэгдүгээрт, Монгол-Алтайн нурууг хэвтээ байсныг босгоод зурсан, хоёрдугаарт, Ховдын хязгаарын зурагт баруун хойд хэсэгт байдаг Бөгтөрмаа голоос хойших уулнуудыг нэмж зурсан, гуравдугаарт, Алтай урианхайн зургийн тэр хэсэгт байгаа гол мөрний нэрийг Ховдын хязгаарын зурагт хасч зурсан гэх мэт ялгамжаа байгаа юм.




Зураг 1-3




Зураг 1-4



Зураг 1-5



Зураг 1-6



Зураг 1-1



Зураг 1-2



Зураг 2 Ховдын хязгаарын зураг (1890) (ТХЗА 1986: 15)

Мөн доор дурдсан Бүрэнт засагчийн 8-р (1869) онд Хятад-Оросын хилийн гэрээ байгуулахад овооны байршлыг нарийн хэмжиж “Ховдын хязгаарыг хэмжсэн зураг”-ыг (Зураг 3) Ховдын хэвэй амбан Күй (奎昌)¹ үйлдсэн боловч Алтай урианхайчууд түүнийг үзээгүй байсан байна. “Зураг 1”, “Зураг 3” хоёр зургийг харьцуулахад Зайсан нуураас урсаж гарах Эрчис голын амны байршил өөр байгаа гэх мэт нэлээн ялгаа харагдах юм.

Дээр дурдсанаар тус өгүүлэлд авч үзэх Алтай урианхайн долоон хошууны дөрвөн зураг нь уул, гол мөрний байршил бараг адил бөгөөд Шар сүм (Соёлыг эрхэлсэн сүм; Зураг 1-1)-ийг зургийн дунд нь тавьж зурсан байдаг. Гэвч “Зураг 1”-ийг бусад гурваас ялгах онцлог нь зүүн, баруун гарын бүгдийн даргын хоёр тамга даруулсанд байгаа юм (“ураг 1-2; мөн Хүснэгт 1-ийг үз).

Зургийн зүүн дээд талд “Байцааваас манай Урианхайд газрын хэмжээ хэдэн хэмээх тоог ер мэдэх хүнгүй. Дөнгөж өртөөгөөр эргэцүүлж бодвоос, өмнө этгээд Улаан боомоос хойд этгээд Ховд голд нийлсэн Согог голын бэлчир хүртэл бүгд найман өртөөний газар болмуй. Бас зүүн этгээд Харгайт, Улиастын бэлчрээс баруун

¹ Бүрэнт засагчийн 5-10 онд Ховдын хэвэй сайдаар ажиллаж, мөн 10 онд Улиастайн жанжны албыг түр хамаарсан. 『清代職官年表』 3-2390.

этгээд Сас харуулд хүртэл бүгд арван хоёр өртөөний газар болмуй” (Зураг 1-1) гэж нутгийн хэмжээг заасан гарчиг шиг тайлбар байдаг. Бусад гурван газрын зураг ч гэсэн ийм гарчиг шиг тайлбартай. Мөн Бадаргуулт төрийн 33-р (1907) оны “Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг” (ТХЗА 1986: 18) мөн иймэрхүү “хэмжээг заасан” тайлбартай байгаа нь Бадаргуулт төрийн 16-р онд үйлдсэн зургийг мөрдсөнийг харуулж байна. “Алтай Урианхайн баруун, зүүн гарын нутгийн зураг” гэсэн бичиг зураг дээр байхгүй, Улсын номын сангийн жагсаалтын нэр болно (Нарантуяа 2008: 24).



Зураг 3 “Ховдын хязгаарын зураг” 『科布多中俄邊境建立界牌鄂博圖』(1869)
http://www.npm.gov.tw/exh98/frontier/img_04.html

Анхаарал татах зүйл нь энэхүү дөрвөн зурагт байгаа хилийн тухай тэмдэглэсэн гурван бичиг юм:

(1) Зүүн доор талд “Байцааваас овооны дотор хөх будаг түрхсэн нь бүрнээ Орос улсад хуваан өгсөн, хөх будаг түрхээгүй нь одоо хоёр улсын хязгаар, хэлхээгийн овоо болмуй” (Зураг 1-4);

(2) Зүүн дунд талд Тарвагатайн протоколын тухай “Энэ Хатууль даваанаас Мааньт гаталган харуулд хүртэл, урьд Бүрэнт засагчийн наймдугаар (1869) онд Ховдын хэвэй амбан Күй (奎昌), Орос улсын түшмэдийн хамт нийлж хуваан тогтоож хэлхээ байгуулсан” (Зураг 1-5);

(3) Дунд дээд талд “Энэ Зэс даваанаас Алагбиг харуулд хүртэл Орос улс лугаа хэлхээ нийлсэн. Бадргуулт төрийн есдүгээр (1883) онд Илийн хэвэй амбан Шан (升泰)², Ховдын туслах амбан Э (額爾慶額)³, Орос улсын амбан Ба (Бабков)⁴ хамт нийлж шинэ тогтоож, хэлхээ байгуулсан” (Зураг 1-6).

Бүрэнт засагчийн үе буюу 1860-80-ад онд Орос, Хятад хоёр улсын хооронд байгуулагдсан хэлэлцээрээр Ховдын хязгаарын хил их өөрчлөгдсөн юм. (2) нь Бүрэнт засагчийн наймдугаар онд (1869) байгуулагдсан Ховдын хилийн протокол буюу хэлэлцээр (Цэдэн-Иш 2003; 『中俄界記』 3а頁), (3) нь 1883 оны Ховд-Алагбиг гол буюу Тарвагатайн хилийн хэлэлцээрийн (мөн 『中俄界記』 3а頁) тухай дурдсан бичиг болно. Хоёр хэлэлцээрээр тогтсон хилийг тус тус нарийн, бүдүүн хоёр улаан зураас зурж харуулсан билээ. “Зураг 3” нь 1869 оны хэлэлцээрээр босгосон овооны зураг юм.


Энэхүү гурван бичиг “Ховдын хязгаарын зураг” (Зураг 2)-т чигээрээ орсон бөгөөд хуучин нутаг дэвсгэрээ бүтнээр нь зураад, иймэрхүү тайлбар зориуд бичсэн нь Хятад, Орос хоёр улсын амбан нар “нийлж” урианхайчуудыг оролцуулахгүйгээр хэлэлцээ хийж шинэ хил тогтоож, тэдний нутгаас Орост хувааж өгсөн гэсэн гомдлоо илэрхийлсэн гэж хэлсэн ч буруудахгүй юм.

² Товч намтар нь 『清史稿』卷 453、頁 12589-д.

³ Товч намтар нь 『清史稿』卷 454、頁 12625-д.

⁴ Иван Федорович Бабков (1827-1905) 1869 онд хилийн хэлэлцээг Оросын талаас удирдах төлөөлөгчөөр томилогдож ажиллахад хошууч генерал, Өрнө Сибирийн цэргийн дүүргийн штабын даргын орлогч, 1883 оны хилийн хэлэлцээний үед дэслэгч генерал, Омскийн цэргийн дүүргийн штабын дарга байжээ (<http://regiment.ru/bio/B/10.htm> (2015.5.10 үзэв)). Мөн Бабков (1912)-г үз.

1.2 Дөрвөдийн баруун аймгийн сул сайд гүн Балдандорж, Галсанжав нарын долоон хошууны урианхайн харьяат нутгийн зураг, Олноо өргөгдсөний гуравдугаар он арван сарын хорин таван (1913)



Зураг 4 “Дөрвөдийн баруун аймгийн сул сайд гүн Балдандорж, гүн Галсанжав нарын долоон хошууны урианхайн харьяат нутгийн зураг” (1913) (ТХЗА 1986: 24)

“Зураг 4” нь Олноо өргөгдсөний 3-р (1913) онд “Зураг 2”-ыг мөрдөж зарим нэг газрын нэр болон 7 хошууны гүнгийн тус тус суух газар, тариалан, мод, давс зэрэг аж ахуйтай шууд холбоотой зүйлийн тухай тэмдэглэлийг нэмж үйлдсэн зураг болно. “Зураг 1” дээр 136 бичиг байхад “Зураг 4” нь нийт 165 бичигтэй, Алтай урианхайн долоон хошууны дөрвөн зургийн дотор хамгийн мэдээлэл сайтай зураг юм. Ингэснээрээ зургийг өргөн барьсан Богд хаанд үнэнч шудрага байхыгаа илэрхийлсэн гэж хэлж болно.

“Зураг 4”-ийг Баруун гарын сул сайд гүн Балдандоржийн хошуунд үйлдсэн бололтой. Учир нь “Зураг 1” дээр зүүн, баруун гарын хоёр тамга дараастай байхад “Зураг 4” дээр зөвхөн Баруун гарын бүгдийн даргын тамга л дарсан байдаг, өөрийн гол нутагладаг Чингэл голын байдлыг бусдаас нарийн тэмдэглэсэн (Зураг 4-1), мөн Булган голын сав нутгийг арай томоор зурсан байгаа юм.

“Зураг 1” (1890)-ээс “Зураг 4” (1913) хүртэлх цаг хугацаанд Алтай урианхайчуудын хувь заяанд мөн ч их нөлөө үзүүлсэн хэд хэдэн үйл явдал болсон юм. 1907 онд Чин улсын засгийн газар Ховдын хязгаарыг хувааж Алтай, Ховдын хоёр хязгаар болгоод, Ховдын туслах сайдыг Алтайн Шар сүмд шилжүүлэн суулгажээ (Li 1991:119-170). 1911 онд Чин улс мөхөж Жавзандамба хутагт хааны

ширээнд сууж Монгол улсыг тунхагласан. Богд хааны цэрэг 1912 оны 8 сард Ховд хотыг эзлээд, Жа лам Дамбийжанцан Шар сүм рүү мордсон боловч 1913 оны 12 сарын 8-ны өдөр байгуулагдсан гал зогсоох протоколоор “Монгол, Синьцзяны хооронд байлдааны гал зогсоох шугамыг тогтоохдоо: Монгол Алтайн нуруугаар уруудаж Алтайн нурууны Ганц модны даваанд хүрээд, Булган голын гольдирлоор уруудан өмнө зүг чиглэн Цагаан түнгэ, Туханцэг, Хараатын ам хүртэлх шугамыг 8 сарын хугацаагаар” (Мөн ном:78-79) тогтоосон юм. Монголын цэргийг Алтайн дайнд явах үеэр “Хаант Орос, Хятадын хооронд 1912 оны эцсээр Бээжинд эхэлсэн хэлэлцээгээр бүх Өвөр Монгол ба Алтайн хязгаарын 10 хошууг⁵ Хятадын мэдэлд таслан авах”-аар (Цэдэн-Иш 2003:74) шийдсэн байжээ.



Зураг 4-1 (Чингэл голын хэсэг)

- 147 Хойд Чингил гол
- 148* Эртний өвгөдийн бумба хүүрний газар
- 149* Урианхайн гүн Балдандоржийн хошуу суух газар
- 150* Энэ гол цөм тариалантай
- 151 Өмнө Чингил гол
- 152 Чанхан гол
- 153* Гүн суух газар
- 154* Чингил голын лам хүрээ
- 155 Ноён овоо
- 156 Ногоон нуур

Тайлбар: Дугаар нь Улсын геодези, зураг зүйн газраас альбом болгон хэвлэхэд тавьсан дугаар болно. Ард нь бичгүүдийг кирилээр буулгасан жагсаалт бий. “*” тавьсан нь бусад зурагт байхгүй зүйлүүд.

Алтай урианхайн баруун гарын захирагч Балдандоржийн хошууны хувьд Олноо өргөгдсөний хоёрдугаар (1912) он зургаан сарын хорин найманд Богд хаанд дагаар орохыг хүссэн бичгийг (УТА А141-1-5:8) өргөсөн байхад “Олноо өргөгдсөний гуравдугаар онд хоёр зуун илүү цэрэг очиж, Өрөнгө, Чингил, Чанхан зэрэг газраа суусан манай нэгэн хошууны ардуудыг тамга захирлын хамт нэгмөсөн шилжүүлэн нүүлгээнд даруй манай нутаг Булган, Дэлүүн, Цэнхэр зэрэг газраа нүүн хүрч ирээд

⁵ Алтайн хязгаарт Алтай урианхайн 7 хошуу, Шинэ торгуудын 2 хошуу, Хошоодын 1 хошуу, нийт 10 хошуу байжээ.

нутаглан суусаар буй” гэж Алтайн наад талд ирсэн тухай 1924 оны Улсын анхдугаар их хуралд бичгээр илтгэсэн байдаг (УТА 266-1-1). Энэ хоёр зуу гаруй цэрэг нь Баруун хязгаарыг тохинуулах хэргийг хавсран туслагч байсан тайж Баярын цэрэг байсан бөгөөд түүний Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яаманд өргөсөн бичигт “манай хошууныг танхай хасаг нар хулгаад булаах ба хохируулан зовоох зэргийн олон учрыг хэлж биднийг хамгаалан авахыг гуйн мэдүүлсэнд сан ба Торгуудын бэйс, гүн, Хошоодын гүнгийн зэрэг гурван хошуунаас зуун илүү тэмээг тэсгэн гаргаж тэрхүү гүн Балдандоржийн харьяат лам хар ардыг цөмийг шилжүүлэн нүүлгэж Булган голд ирүүлж нутаглан суулгаж буй” (УТА АЗ-1-444:12; cf. Нямдорж 2006:143) гэж бичсэн байдаг. Энэхүү бичиг Олноо өргөгдсөний гуравдугаар оны есөн сарын тавных байх учраас Булган голд нүүж ирсний дараа “Зураг 4”-ийг үйлдсэн болно. Хуучин Ховдын сайд, 1907 оноос Алтайн сайдад захирагдаж явсан Алтай урианхайн 7 хошуу Богд хааны Монгол улсад дагаар ороод Дөрвөдийн баруун гарын чуулганы Үнэн зоригт хан аймагт багтаан хавсрах болсон юм.

Дээрх тайж Баярын бичигт “манай хошууныг ... хамгаалан авахыг гуйн мэдүүлсэн” гэж байгаа боловч, тэд Чингил гол зэрэг газрыг Монголын цэрэг хамгаалан авахыг хүссэнээс биш Алтай давуулан нүүлгэхийг хүсээгүй байж болох юм. Мөн дээр дурдсан 1924 оны их хурлын илтгэлд “олон тариалан, хадлан, ой мод, жимс, тэжээл, үст эвэрт ан гөрөөс зэрэг дэлхийн баялаг үлэмж газар” гэж Алтайн цаадах нутгаа танилцуулаад, сүүлд нь тэр нутаг одоо “цөм хятад, хасаг этгээд эзэрхэж ашиглан бүхүй учрыг илтгэж тэрхүү шим өнтэй нутаг газрыг дотоодод хамгаалан авч, ядуу урианхайн хэдэн хошууны ардуудыг хүмүүжүүлэн нутаг үндсээр бүрэн бүтэн болгож тэнхрүүлэхийг үнэхээр эрмэлзэн хүсмүй” (УТА 266-1-1) гэж илтгэсэн байдаг. Энэхүү газрын зурагт Чингил голыг онцгойлон нарийн зүйлийг оруулсан нь тэдний хувьд тэр газар амин чухал газар болохыг илэрхийлсэн хэрэг гэж хэлж болно.


Иймээс “Зураг 4” нь нэг талаас нутгийнхаа байдлыг нарийн тодорхой тэмдэглэсэнээрээ Богд хааны засгийн газарт үнэнч шударга байхыг илэрхийлсэн, нөгөө талаас Чингил голоос “хүчээр” нүүлгээд, тэр газрыг хамгаалан авч өгөхгүй явдалд гомдсоноо мэдүүлсэн зураг болно.

1.3 Урианхайн зүүн, баруун гарын долоон хошууны нутгийн зураг 『烏梁海左右翼七旗地圖』 (Дундад иргэн улсын 8-р он 12-р сар) (1920)

“Зураг 5” нь “Зураг 4”-ийг мөрдөн зурж Дундад иргэн улсад өргөн барьсан зураг болно. 1919 оны 6 сард Хятадын засгийн газар Алтайн хязгаарыг Ашандао (阿山道) болгон Шинжан мужийн харьяанд оруулжээ. Дараа нь мөн 1919 оны 11 сард Хятадын цэрэг Хүрээг эзэлж Монголын автономийг устгасан байдаг. Үүний дараа Хятадын засгийн газарт өргөсөн учраас дээр нь орчуулгын хятад бичигтэй цаас

наалттай байдаг. Харин “Зураг 4”-д байсан хошууны гүнгийн суух газар, тариалан, мод, давсны тухай гэх мэт нарийн зүйлийг хассан байна.

Энэхүү зургийг “Зураг 4”-тэй мөн адил баруун гарын Балдандоржийн хошуунд үйлдсэн учраас зүүн гарын тамгагүй, ганц баруун гарын тамгыг даруулсан байдаг. Зүүн гарын сул сайд байсан Галсанжав 1914 онд цөөн хүнийг аваад тамгатайгаа Алтай давсан байхад Балдандорж ноён, түүний төрсөн дүү Чултэм да лам тус бүс нутагт нэлээн нөлөөтэй байсан юм.




Зураг 5 “Урианхайн зүүн, баруун гарын долоон хошууны нутгийн зураг” (1920)
Берлин мужийн номын сан

“Зураг 5”-ыг бусад гурван зургаас онц ялгах зүйл нь Алтай нуруунаас Хав гол хүртэлх газрыг хөх өнгөтэй зураасаар хүрээлэн заасан хэрэг. Энэ нь Бүрэнт Засагчийн 11-р онд (1872) Алтай уулаас Хав гол хүртэлх, тойрон хүрээ нь 700 газар бүхий Алтай урианхайн нутгийг Тарвагатайн сайд Ховдын сайдаас түр аваад, “Цагаан гэгээн”⁶ хэмээн Тарвагатайн өөлдийн дунд алдаршсан, Ганьсугийн монгол гаралтай лам Гунгаажалсаныг 800 гаруй шавь нартай нь суулгасан (Туна 1990: 397) газар мөн болно (Зураг 5-1).

Гунгаажалсан Бүрэнт Засагчийн эхний үеэр хуйхуйн бослогыг дарахад Тарвагатайн өөлд цэргийг удирдан байлдаад их гавъяа байгуулсан билээ. Бүрэнт засагчийн 3-р (1864) онд Орос, Хятад Тарвагатайн хилийн гэрээ байгуулснаас хойш, хуучин

⁶ Цэвээн (1934:123) мөн Цагаан гэгээн Алтай урианхайчуудыг “хэрхэн идчихсэн”-ий талаар бичсэн байна.

Хятадынх байж Оросын нутаг дэвсгэр болсон газар амьдарч байсан казахууд шинэ тогтоосон хилийг давж сайн өвөлжөө ихтэй Тарвагатай руу бөөн бөөнөөр нүүж ирдэг болжээ. Тарвагатайн сайд арга ядаж ирсэн казахуудыг Ховдоос түр авсан Хав голын хавь нутагт нүүлгэн Гунгаажалсанаар захируулсан юм. Гунгаажалсан харьяат казахуудад чанга хатуу хандсан улмаас олон казах Ховд руу зугтаж Алтайн урианхайн нутгийн гүн рүү орж суурьших болжээ. Бадаргуулт төрийн 15-р онд (1889) Гунгаажалсан өөрийн байгуулсан Шар сүмээс Тарвагатайн харьяат Хар-ус руу нүүсэн боловч газар нь Тарвагатайн мэдэлд хэвээр үлдсэн юм. Үүнээс болж Ховд, Тарвагатай хоорондын газрын маргаан үргэлжилж, тус нутаг дахь казахуудын асуудал улам хурц болсон ажээ (Zhan & Wan 2002). Газар “түр” өгөхөд Алтай урианхайн ноёдоос зөвшөөрөл авсан боловч эзэн хааны зарлиг буусан учир татгалзах аргагүй байсан нь тодорхой.



Зураг 5-1

Алтай урианхайн нутагт казахууд орж ирсэн тухай 1924 оны Улсын анхдугаар их хурлын илтгэлд, "... урьд Чин улсын үед хар хасаг чантуу орж ирснийг хаан эзний зарлигаар манай нутагт багтаан суулгаж, жил бүр өвс бэлчээрийн хөлс, тэмээ, адуу, үхэр, хонь тус бүр нэг зуугаас нэжгээдийг хураан авч, бас хасаг хүмүүс тариа тарихад тариалангийн хөлсийг зүй зохисоор тусгай хураан авч ..." (УТА 266-1-1) гэж илтгэсэн байдаг. Бэлчээр, тариалангийн хөлс хурааж авахыг ардын засгийн газраас 1926 оноос зогсоож, Алтай урианхайн нутгаас казах хошуудад нутаг газар олгох бодлого хэрэгжүүлж эхэлсэн билээ (УТА 168-37-6).

Чин улсын үед Ховд, Тарвагатайн сайд нар Алтайн хязгаарыг өөрийн харьяат газраас казахуудыг нүүлгэн суулгах зориулалтын газар гэж үздэг байсан (Zhan & Wan 2002: 32) бол Монголын ардын засаг мөн тийнхүү бодлогыг уламжлан мөрдсөн. Үүний үр дүнд 1940 онд "казах, урианхайн ард түмний санаачилгаар" Баян-Өлгий аймаг байгуулагдсан, мөн 1940-ээд онд Чойбалсан, Сталины дэмжлэгээр Оспаныг ашиглаж Алтайн хязгаарын цаадах нутгийг Хятадаас авах оролдлого хийсэн юм.


Хоёр хилийн хэлэлцээрийн тухай тайлбарыг Алтай урианхайчууд өөрөө бичиж, шинэ тогтоосон хилийг улаан шугамаар өөрөө зурсан (сүүлд нэмж оруулаагүй) нь 1890 оны зураг "Зураг 1", түүний дараагаар Ховдод үйлдсэн "Ховдын хязгаарын зураг" (Зураг 2)-ийг үзэхэд тодорхой байгаа. "Зураг 5"-д байгаа хөх зураас ч гэсэн мөн тэд өөрсдөө зураад, маргаантай газрыг зааж, улмаар гомдлоо Хятадын засгийн газарт мэдүүлсэн гэж үзэж болно.

1.4 Алтай урианхайн долоон хошууны нутгийн зураг, Монгол улсын арван наймдугаар он таван сарын хоёр (1928)

Алтай урианхайн долоон хошууны байдлыг зурсан дөрвөн зургаас хамгийн сүүлийнх нь "Зураг 6" болно. Даруулсан тамга нь "Алтай урианхайн Зүтгэлт засгийн хошууг захирагч тамга" гэсэн бичигтэй байгаа болохоор хуучнаар "Зүтгэлт гүн" буюу 1927 он хүртэл Алтай урианхайн чухам чуулганы даргаар ажилласан Цагаанбилигийн хошуунд үйлдсэн бололтой. Үүнийг Бадаргуулт төрийн 16-р оны газрын зургийг (Зураг 1) яг мөрдөж зурсан байгаа юм.

Алтай урианхайн долоон хошуу хуучин аймгаар байгаагүй, Ховдын сайд, Алтайн сайд, Алтайн захирагч нарт шууд захирагдаж явдаг байжээ. Алтай урианхайн чухам чуулган хэрхэн байгуулагдсан тухай Олноо өргөгдсөний арван хоёр (1922) он найман сарын хорин нэгний Цагаанбилигийн бичигт, "Зарлигаар зарсан Ховд зэрэг газрыг тохиуулах төлөөний сайд жанжин Хичээнгүй баатар бэйл, Зарлигаар зарсан Ховдод сууж хэрэг шийтгэгч сайд Үнэн зоригт хан Танаа, ... Манай Алтай урианхайн долоон хошуу анх Монгол улсыг тусгаар байгуулах цагт Богд хааны гэгээн соёлд дагаар орж, хүнд зузаан хишгийг хүлээн хүртэж, Дөрвөдийн баруун аймагт хавсарган захирагдаж асан бөлгөө. Хараахан цагийн самуунд Шинжан мужийн

Даоин-аас эзэрхэн захирсан зүйл буй боловч, дараа Гадаад Монгол улс төрийг нэгэнт уг хэвээр мандуулсан тухайд манай урианхайн баруун гарын бэйс Жамьянжавын тамгыг хамаарсан да лам Чүлтэмийн газраас урианхайн долоон хошууг Иргэн улсаас нэгмөсөн ангижруулан авч, тусгай газраа захируулахыг байлгаж, урьдын ёсоор болгон, хошуу сум хөрөнгийг тэгшлэн, аливаа алба залгамжлах чуулган болгож, хишиг хүртээхийг гуйж мэдүүлснээр үл барам, бидний хошууд мөн нэгэн адил санаа цутган дагасан ...” (УТА 263-1-1) гэж тэмдэглэсэн байдаг. Ингээд гуйсан ёсоор Алтай урианхайн долоон хошуу тусгай нэг аймаг болж явсан билээ.



Зураг 6 Алтайн урианхайн долоон хошууны нутгийн зураг
Монгол улсын 8-р (1928) он 5-р сарын 2

1924 оноос орон нутагт шинэ захиргаа зохион байгуулах бодлого явуулахад Алтай урианхайн долоон хошууны хувьд Монгол, Хятад хоёр улсад нутаг нь ч, хүн нь ч хуваагдсан, казахуудтай бэлчээрийн маргаан тасралтгүй байгаа гэсэн шалтгаан гаргаж, шинэ захиргаа байгуулаагүй байтал 1927 оны аймгийн зургадугаар их хурлын тогтоолын ёсоор долоон хошуу нь тусгай хоёр хошуу болж, Монгол улсын 17-р оны 11 сарын 25-наас ажилласан билээ (УТА 266-3-2). Шинэ хоёр хошуу тус тус хуралдаад Алтай хан уулын урианхайн зүүн хошуу Т.Сурахбаярыг (УТА 11-1-

273), Алтай хан уулын урианхайн баруун хошуу Чүлтэм да ламыг тус тус даргаар сонгосон юм (УТА 266-3-2).

Энэхүү “Зураг 6”-ийг шинэ захиргаа зохион байгуулж ажиллуулсны дараа хуучин аймгийн дарга Цагаанбилиг шинэ хоёр хошууг төлөөлж үйлдсэн гэж хэлж болно. Үүгээр шинэ захиргаа байгуулсан явдлаа Монголын засгийн газарт мэдүүлсэн юм.

2 Алтай урианхайн долоон хошууны нутгийг зурсан бусад зургийн тухай

Алтайн хязгаарын нутгийн асуудал Монгол, Хятад, Орос гурван улсын хувьд маргаантай, чухал асуудал байсан учраас Алтай урианхайчуудын өөрөө зурсан зургаас гадна тус бүс нутгийг тусгай зурсан зураг ч байгаа юм.

“Зураг 7” нь “Маршалын номын сангаас авчрав, 1952 оны 2 сарын 20, Лувсанцүлтэм” гэсэн тайлбартай “Дөрвөдийн баруун зүүн гарын аймгийн нутгийн зураг”-ийн Алтайн хязгаарын хэсэг юм (УТА М167-118-93; Гантулга 2000:222). Ямар нэг хэвлэгдсэн газрын зураг дээр Дөрвөдийн хоёр аймгийн хошуудын нэрийг бийрээр бичсэн байдаг. Тэгэхэд зөвхөн Алтай урианхайн ноёдын нэрийг тэмдэглэсэн нь Чойбалсан энэхүү нутагт онц сонирхож судалсныг харуулж байна. Энэ нь “Сайд жанжин гүн Нацагдорж” ноён болсон 1914 оноос 1919 оны байдлыг харуулсан зураг болно. “Шар да хэмээх Ёст гүн” Бадрах нь “Зураг 8” дээр байгаа Очиржавыг залгамжлсан ноён байх учраас “Зураг 7” нь “Зураг 8”-аас хойших байдлыг зурсан байх ёстой. Энэ хоёр зураг хэдэн оны байдлыг зурсан, хэзээ үйлдсэн зэргийг тогтооход ноёдын алба хаасан хугацаа, дэвсгэр болсон хэвлэгдсэн газрын зургийн тухай судлах шаардлагатай байна

Энэхүү “Зураг 7” дээр Алтай урианхайн хошууны хилийг зурсан байгаа нь дээрх 1924 оны Улсын анхдугаар их хурлын илтгэлд, “манай урианхайн долоон хошууны нутаг газар завсардан хуваасан хилгүй холицолдон суусан” (УТА 266-1-1) гэсэнтэй нийцэхгүй, иймэрхүү хил үнэндээ байсан нь эргэлзээтэй байна.


Мөн дэвсгэр болсон зурагт Монгол-Хятадын улсын хилийг Улаан даваа, Машийн даваа, Долоон нуурын даваагаар татсан байгаа. Энэ нь одоогийн Ховд аймаг (Дуут, Мөнххайрхан сум), Баян-Өлгий аймаг (Булган сум) хоорондын хил болно. Шинжанаас үйлдсэн “Ховд, Алтайг (1907 онд) хуваасан дараах Алтайн хязгаарын зураг” 『科阿分治後阿爾泰圖』 (Зураг 8) дээр мөн ингэж Ховд-Алтайын хилийг татсан байдаг. Үүнийг Алтайн захиргааны дүүргийн Хэргийг ерөнхийлөн шийтгэх газрын хэлтсийн дарга (阿爾泰行政區總務處科長) Жоу Шюанжи (周宣極) үйлдсэн гэж

зургийн баруун доор захад бичсэн байдаг. Энэ албан тушаалын орон тоо 1915 онд бий болсон (Zhan 1980: 646) учраас үүнээс хойш үйлдсэн зураг болно. Мөн Хятад түшмэл Шюү Шизэн (徐時震) 1915 оны Хиагтын гэрээгээр тогтоосончлон Алтай урианхайчууд суудаг нутаг бүхэлдээ (одоогийн Баян-Өлгий аймаг, Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан сум, Буянт сумын хэсэг) Хятадын нутаг дэвсгэр мөн гэсэн байр суурьтай хилийн хэлэлцээнд хандах ёстой бөгөөд тухайн бүс нутгийг сайн судлаад, нарийн газрын зураг үйлдэх шаардлагатай байна гэсэн санаагаа 1917 оны 1 сард Хятадын засгийн газарт танилцуулсан (Чэнь 1922: 2-р хэсэг 104-106) учраас түүний санааны дагуу үйлдсэн байж болох юм.




Зураг 7 “Дөрвөдийн баруун, зүүн гарын аймгийн нутгийн зураг” (хэсэг) (1914-1919)
(Гантулга 2000:222; УТА: М167-118-93?)

1 Эгтэй гүн Төрбатын хошуу, 2 Зоригт гүн Сандунжавын хошуу, 3 Сайд жанжин гүн Нацагдоржийн хошуу, 4 Шар да хэмээх Ёст гүн Бадрахын хошуу, 5 Саруул гүн Гомбожавын хошуу, 6 Дархан бэйс Жамьянжавын хошуу, 7 Да Зүтгэлт гүн Цагаанбилигийн хошуу



Зураг 8 “Ховд, Алтайг хуваасны дараах үеийн Алтайн хязгаарын зураг”
 『科阿分治後阿爾泰圖』(1915-?) (Zhan 1980:248)



Зураг 8-1 (“Зураг 8”-ын хэсэг) 1 Зүүн гарын гүн Төрбатын хошуу, 2 Зүүн гарын гүн Сандунжавын хошуу, 3 Баруун гарын гүн Очиржавын хошуу, 4 Зүүн гарын гүн Галсанжавын хошуу, 5 Зүүн гарын мэйрэн зангийн хошуу, 6 Баруун гарын гүн Гомбожавын хошуу, 7 Баруун гарын бэйсийн хошуу; ○Казахын бэлчээр; — Хошууны хил; — Алтайн урианхай, Хошууд, Торгуудын хил

Алтайн хязгаар дахь хоёр улсын хил тогтвортой биш байсан юм. Хятадын хувьд Алтайн хязгаар бүтнээрээ Хятадад орох ёстой гэсэн байр суурьтай байхад 1913 оны байлдааны гал зогсоох шугмыг дээр дурдсанчлан “Монгол Алтайн нуруугаар уруудаж Алтайн нурууны Ганц модны даваанд хүрээд, Булган голын гольдирлоор уруудан” (Цэдэн- Иш 2003:79) тогтоосон байжээ. 1930-аад оны Монголд үйлдсэн газрын зураг бол Өрөнгө голын салбар болох Цагаан голын цаагуур хил татаж зурсан байдаг. Жишээ нь 1931-1932 онд Шинжлэх ухааны хүрээлэнгээс үйлдсэн “Монгол ард улсын газрын зураг” (Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн номын сан; <http://mongol.tufs.ac.jp/landmaps/16.html>), 1934 оны “Географический атлас Монгольской Народной Республики”-ийн зураг, 1937 оны Симуквын “ногоон зураг”

хэмээх “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын газрын зураг”⁷ болно. Хоёр улсын хил тухайн үеийн Шинжан болон Дэлхийн байдлаас болоод тогтоогүй байгаад 1962 од байгуулсан Монгол-Хятадын хилийн гэрээгээр “10 хошууны дундуур ерөнхийдөө Алтайн нурууг барьж, шинэ хил тогтоосон” юм (Цэдэн- Иш 2003:135).

“Зураг 8”-д Алтай урианхайн нутгийг “Зураг 7”-д зурснаас багаар зураад казахуудын бэлчээрийг томоохон зааж зурсан байдаг. 1910-аад оны үнэн байдал нь “Зураг 8”-д нэлээн ойр байсан гэж хэлж болох юм. Юутай ч гэсэн ХХ зууны эхний үеийн Алтай урианхайн газар нутаг, тэдний өөрөө зурдаг зураг шиг өргөн уудам биш, “Зураг 8” үзүүлж байгаа шиг казахуудад шахагдсан бага хэмжээгээр үлдсэн нутаг болсон ажээ.

ДҮГНЭЛТ

Дээр авч үзсэн дөрвөн зураг нь Алтай урианхайчуудын хувьд газрын зураг зурсан газар нутгийн тухай санаагаа илэрхийлж дамжуулах арга хэрэгсэл байсныг харуулж байна. Зургийн зураглалын нарийн бүдүүн, тэмдэглэсэн бичгийн тооны их багаас ч гэсэн зургийг өргөн барьсан засгийн газарт тэд хэрхэн үнэнч шудрага байсныг⁸ мэдэж авч болох юм.

Алтай урианхайчууд Бүрэнт засагчийн үеийн Орос-Хятадын хилийн хэлэлцээрээс эхлээд, казахууд, “Цагаан гэгээн” хэмээх Гунгаажалсан тэргүүтэй өөлд, хуйхуй нарт нутгаасаа хөөгдөөд явсан билээ. Орос-Хятадын хилийг хоёр улсын түшмэд “нийлж” Алтай урианхайчуудын оролцлогогүй тогтоосон явдлыг хятадууд газар орноосоо баруун хойд хязгаарыг алдсан гэж өөрсдийн гунигтай түүх болгон өгүүлдэг боловч⁹ Алтай урианхайчуудын хувьд өөрийн түүхийг булаалгаж байгаа хэрэг (a usurpation of history) мөн болно.

Тарвагатай, Ховдын сайд нар хэлэлцээд Алтай урианхайн нутгаас, Алтай нуруунаас Хав гол хүртэлх газрыг Тарвагатайд “түр” өгөөд казахуудыг суулгахад ноёд нь зөвшөөрсөн ч гэсэн тэр газар чигээрээ казахуудын нутаг болсон ажээ. Алтай урианхайн нутагт суусан казахуудаас ноёд нь бэлчээр, тариалангийн хөлс авдаг байсан боловч үүнийг 1926 оноос ардын засгийн газраас зогсоосон юм. Угаасаа зэвсэг сайтай, хүчирхэг казахууд урианхайчуудын бэлчээрийг шууд булааж авах (Benson 1998: 62), өвөлжөөг эвдэх явдал их үзэгдэж байсан юм (УТА 168-37-6). Ховд, Тарвагатайн сайд нарын хувьд Алтай урианхайн нутаг өөрийн нутгаас казахуудыг

⁷ Энэхүү “ногоон зураг”-т Цагаан голын цаагуур, Ноён овоо, Улаан бомын овоогоор хил зурсан байдаг. Мөн сонирхолтой нь Өмнө Чингэл голд “Да ламын сүм”-ийг зурсан зүйл юм.

⁸ Дөрвөн зургийн дотор 1913 оных нь нийт 165 бичигтэй, бусад гурав нь 136 бичигтэй боловч зарим бичиг нь хоорондоо ялгаатай байдаг.

⁹ Жишээ нь Тайваны музейн “The Lost Frontier” хэмээх үзэсгэлэн болно. (<http://www.npm.gov.tw/exh98/frontier/en1.html> 2015.5.20)

нүүлгэн суулгах газар гэж үзэж байсан бөгөөд энэ нь Алтайн хязгаарыг байгуулах гол зорилгын нэг болсон билээ. Ийнхүү Алтай урианхайн нутгийг казахуудыг нүүлгэн суулгаж тохинуулах зориулалтын газар болгох бодлогыг ардын засгийн Монгол уламжлан Чойбалсангийн үеэс хойш ч гэсэн явуулж байсан юм.

Алтай урианхайн долоон хошууны нутгийг зурсан дөрвөн газрын зураг Алтай урианхайчуудын иймэрхүү түүхийг харуулж, тэдний санаа, гомдол, шүүмжлэл, мөрөөдлийг илэрхийлж дамжуулан, одоогийн бид нарт ч гэсэн мэдүүлж байгаа юм.

НОМ ЗҮЙ

- Бабков, И.Ф. (1912) Воспоминания о моей службе в Западной Сибири 1856-1875 гг. С.Петербург. (<http://nblib.library.kz/elib/Sait/Редкие%20книги/И.Ф.Бабков/1.Bobkov.html> 2015.5.10 үзэв)
- Benson, L. (1998) *China's Last Nomads: The History and Culture of China's Kazaks*. M.E. Sharpe, Inc.
- Болд, Б., Туяа, Б. (2011) *Оспан хэн байв- Монгол баримт юу өгүүлэв*. УБ.
- Чэнь (陳崇祖) (1922) 『外蒙古近世史』(Гадаад Монголын орчин үеийн түүх), 商務印書館.
- Гантулга, Ц. (2000) *Алтайн урианхайчууд*. УБ.
- Географический атлас Монгольской Народной Республики* (1934) Издание Клуба имени Ленина. М. УБ.
- Harley, J.B. & D. Woodward (eds.) (1987) *The History of Cartography*, Vol. 1. Chicago & London.
- Камимүра, А. (хэвлэлд) Алтай урианхайчууд “эх орноосоо дүрвэсэн” үү, “эх нутагтаа буцсан” уу? -1930 онд Алтайн урианхайчууд Алтай давсан нь-. In: На. Сүхбаатар et al. (eds.) *Урианхайн түүх соёлын судалгаа*. УБ.
- Камимүра, А. (2013) Алтайн Урианхайчууд: Монголын социалист угсаатны зүйн онолд, *MONGOLICA* 46(2013): 103-110.
- Камимүра, А. (2012) Монголын хошуу нутгийн зургийн зураг зүйн хувьсал ба Чин улсын Монгол захиргаа. In: Х, Фүтаки, А. Камимүра, Э. Равдан, and Л. Чулуунбаатар (eds.) *Монголын орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд*. УБ. pp. 1-16.
- Li (李毓澍) (1991) 『蒙事論叢』(Монголын тухай өгүүллийн түүхэр)台北(Тайпэй): 里仁書局.
- Минис, А., Сарнай, А. (1960) *БНМАУ Баян-Өлгий аймгийн казах ард түмний түүхээс*. УБ.
- Нарантуяа, Ч. (2008) *Монгол дахь монгол гар бичмэл судрын гарчиг*. УБ.
- ГХЗА (1986) *Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн Альбом*. Улсын геодези, зураг зүйн газар. УБ
- Цэдэн-Иш, Б. (2003) *Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс*. УБ:
- Цэвээн (Čeveng, J.) (1934) *Darqad, köbsögöl nayur-un uriyangqai, dörbed, qotong, bayad, ögeled, mingyad, jaqacın, torγud, qošod, čaqar, dariyangγ-a, altai-yin uriyangqai, qasay, qamniyan nar-un γarul ündiüsü bayidal-un ögülel*. Bügde nayıramdaqu mongγol arad ulus-un sinjileküi uqayan-u küriyeleng. (Ts. Zhamtsarano (1979) *Ethnography and Geography of the Darkhat and Other Mongolian Minorities*, with a Mongolian-English Glossary by John R. Krueger. The Mongolia Society Special Papers, Issue Eight. The Mongolia Society.)
- Tuna (吐娜) (1990) 「棍噶扎拉参与額魯特蒙古」(Гунгаажалсан ба Өөлд монгол)『內蒙古師範大學學報』1990-3.
- Zhan (張大軍) (1980) 『新疆風暴七十年』(Шинжаны 70 жилийн шуурга)台北(Тайпэй): 蘭溪出版社.
- Zhan & Wan (张荣, 王希隆) (2002)「清末科塔借地之争述论」(Чин улсын сүүлийн үе дэх Ховд, Тарвагатай хоорондын газрын маргааны тухай өгүүлэх нь)『中国边疆史地研究』12-1(2002):24-32.

SUMMURY

This paper aims at clarifying how a map functions as a media to represent and convey the history of the land, an attachment to the land of the people who made it, by exploring four maps of the Altai urianhai's seven banners which the Altai urianhai produced themselves and dedicated to the government they pledged loyalty to.

The maps are: (1) "Map of the territory of the Left and the Right wings of the Altai urianhai" dated 1890; (2) "Map of the territory belonging to Urianhai's seven banners of "Sul said" Lord Baldandorj and Lord Galsanjav of the western Durved aimag" dated 1913; (3) "Map of the territory of the seven banners of the Left and the Right wings of Urianhai" dated 1920; (4) "Map of the territory of the seven banners of Altai urianhai" dated 1928. These four maps are drawn in one pattern, but dedicated to different governments: (1) to the government of Qing dynasty, (2) to the Mongolian government of Bogd emperor, (3) to the government of the Republic of China, (4) to that of the People's Republic of Mongolia.

Map (1) was the first one and produced for 大清會典 (Collected statutes of the Great Qing) in 1890. On this map and the other three maps, there are two red lines which show the borders defined in Russian-Chinese Border treaties in 1869 and 1883, and descriptions about the treaties saying that Russian and Chinese officials conspired together to define these borders. These treaties gave parts of their land to Russia. With the lines and descriptions on the maps, they conveyed their complaints to the governments that the issues on their land had been decided with no participation of them.

Map (2) was produced in the winter of 1913 after the army of Bogd Khaan moved the Altai urianhai in the summer of the same year, from the valley of the Chingel River on the west slope of the Altai Mountains which was belonged to Xinjiang, China, to the basin of the Bulgan River in the east side of the Altai Mountains which was belonged to Mongolia. The valley of the Chingel River was their main homeland and they had a strong attachment to the land. To convey their attachment to the government, they wrote detailed descriptions about the valley of the Chingel River on the map, which are not found on the other three maps.

Map (3) was dedicated to the government of China in 1920 after the Altai urianhai banners belonged to China as a district of Xinjiang. They circled in a blue line the land which the Hovd governor had lent to the Tarbagatai governor for the purpose of moving and settling those kazakhs who came in a great mass to the territory of Tarbagatai after the Russian-Chinese border treaty of Tarbagatai in 1864. They lost a claim to the land and it had never returned to the Altai urianhai. The blue line on the map represented their complaint about this.

Map (4) was produced in 1928 and dedicated to the government of Mongolia after the establishment of a new administrative organization of the Altai urianhai. Their territory had been shrunk to a small area in the eastern side of the Altai Mountains. However, they drew their past territory as a whole on the map.

The case of the Altai urianhai shows vividly how a map functions as a media to represent and convey an attachment to and/or a complaint about an issue on the land of the people.